ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/129/СТА-ТШ3**

Цахим хуудас: www.audit.mn

Улиастай сум

2022 он

Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn

Аудитын менежерийн үүрэг гүйцэтгэгч : Б.Дагвасүрэн
Утас:99014227
Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn

Аудитор: Б.Мөнхнасан
Утас:90066888
Цахим хаяг: munkhnasanb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ....................................................**Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....................................................4

3. Аудитын тайлан....................................................8

3.1 Ерөнхий зүйл....................................................8

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....................................................9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....................................................9

3.4 Материаллаг байдал ....................................................9

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....................................................10

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....................................................10

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....................................................10

3.8 Аудитын гол асуудал ....................................................11

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ................11

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....................................................11

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....................................................11

4. Аудитын илрүүлэлт ....................................................11

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....................................................12


## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2022.02.24 № 1302/260

танай ________ -ны № ________ -т

ДӨРВӨЛЖИН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.БЯМБАСҮРЭН-д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

*Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх гэсэн заалт зөрчсөн байна.*

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Audit(D)A4-тоот/2022

01202531б

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **37,081,943.74** | **32,196,500.00** |
| **33** | **АВЛАГА** | 729,103.74 | 172,000.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 566,659.27 | 00.00 |
| **335** | **Бусад авлага** | 162,444.47 | 172,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 162,444.47 | 172,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 36,352,840.00 | 32,024,500.00 |
| **351** | **Түүхий эд материал** | 13,131,000.00 | 13,071,100.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 12,845,100.00 | 13,031,100.00 |
| 35130 | Эм боох материал | 285,900.00 | 40,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 23,221,840.00 | 18,953,400.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 151,440.00 | 124,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 11,280,200.00 | 11,754,900.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 11,790,200.00 | 7,074,500.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,472,125,781.42** | **1,446,661,805.78** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,472,125,781.42 | 1,446,661,805.78 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,462,567,781.42 | 1,437,433,805.78 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,591,800,000.00 | 1,591,800,000.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -175,761,249.98 | -202,291,249.94 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,184,326.00 | 43,192,126.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -6,537,778.60 | -12,103,923.76 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,137,812.69 | 21,059,537.69 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -5,678,654.59 | -4,646,010.11 |
| 39217 | Ном | 423,325.90 | 423,325.90 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 9,558,000.00 | 9,228,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,748,000.00 | 9,748,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -190,000.00 | -520,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,509,207,725.16** | **1,478,858,305.78** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **9,168,123.37** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 9,168,123.37 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 9,168,123.37 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 128,733.37 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 00.00 | 9,039,390.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,509,207,725.16** | **1,469,690,182.41** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,509,207,725.16 | 1,469,690,182.41 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 29,404,158.69 | 29,404,158.69 |
| 51101 | Өмч: - төрийн | 29,404,158.69 | 29,404,158.69 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,477,168,924.47 | 1,437,651,381.72 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,477,168,924.47 | 1,477,168,924.47 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -39,517,542.75 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,634,642.00 | 2,634,642.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,509,207,725.16** | **1,478,858,305.78** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,781,917,569.83** | **299,577,138.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,484,705,169.83** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,484,705,169.83 | 00.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,484,705,169.83 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,484,705,169.83 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **297,212,400.00** | **299,577,138.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 235,322,400.00 | 249,370,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 235,322,400.00 | 249,370,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 61,890,000.00 | 45,253,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 61,890,000.00 | 45,253,200.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 4,953,138.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 4,953,138.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **308,068,593.45** | **331,595,180.75** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **308,068,593.45** | **331,595,180.75** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 271,646,095.84 | 299,107,348.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 157,443,660.14 | 171,007,230.20 |
| 210101 | Үндсэн цалин | 137,101,577.14 | 145,412,032.20 |
| 210102 | Нэмэгдэл | 20,090,083.00 | 21,149,633.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 252,000.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 4,445,565.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,531,696.96 | 22,268,791.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 15,199,456.96 | 15,445,994.38 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,583,333.00 | 1,707,157.75 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,266,668.00 | 1,365,726.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 315,571.00 | 335,595.95 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,166,668.00 | 3,414,316.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,166,530.43 | 54,022,692.81 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,853,990.43 | 1,518,152.81 |
| 210302 | Түлш, халаалт | 45,393,440.00 | 51,326,540.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 919,100.00 | 1,178,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,776,429.00 | 3,297,460.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,094,035.00 | 730,440.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,035,694.00 | 788,650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 565,000.00 | 640,670.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 75,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,081,700.00 | 1,062,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 19,383,565.00 | 12,231,109.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 184,400.00 | 1,976,400.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,199,165.00 | 10,254,709.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 104,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 104,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 230,000.00 | 560,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 230,000.00 | 560,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 350,100.00 | 575,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 350,100.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 575,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20,764,114.31 | 35,038,865.64 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,168,300.00 | 567,090.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 19,595,814.31 | 34,471,775.64 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 36,422,497.61 | 32,487,831.92 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | 00.00 | 00.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 4,953,138.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 4,953,138.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 22,699,058.04 | 27,479,952.26 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,699,058.04 | 27,479,952.26 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 13,723,439.57 | 54,741.66 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,723,439.57 | 54,741.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **1,473,848,976.38** | **-32,018,042.75** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,898,200.77 | 7,499,500.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,695,266.77 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 202,934.00 | 7,499,500.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -1,898,200.77 | -7,499,500.00 |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **1,471,950,775.61** | **-39,517,542.75** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 21,496,158.69 | 2,634,642.00 | 4,608,686.02 | 00.00 | 28,739,486.71 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **21,496,158.69** | **2,634,642.00** | **4,608,686.02** | **00.00** | 28,739,486.71 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 7,908,000.00 | 00.00 | -13,489,479.89 | 00.00 | -5,581,479.89 |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,404,158.69** | **2,634,642.00** | **1,477,168,924.47** | **00.00** | 1,509,207,725.16 |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,404,158.69** | **2,634,642.00** | **1,477,168,924.47** | **00.00** | 1,509,207,725.16 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **29,404,158.69** | **2,634,642.00** | **1,477,168,924.47** | **00.00** | 1,509,207,725.16 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -39,517,542.75 | 00.00 | -39,517,542.75 |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **29,404,158.69** | **2,634,642.00** | **1,437,651,381.72** | **00.00** | 1,469,690,182.41 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **297,415,334.00** | **299,577,138.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **202,934.00** | **00.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 202,934.00 | 00.00 |
| 120009 | Бусад орлого | 202,934.00 | 00.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **297,212,400.00** | **299,577,138.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 235,322,400.00 | 249,370,800.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 235,322,400.00 | 249,370,800.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 61,890,000.00 | 45,253,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 61,890,000.00 | 45,253,200.00 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | 00.00 | 4,953,138.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 00.00 | 4,953,138.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **292,132,500.00** | **290,569,338.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **292,132,500.00** | **290,569,338.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **255,710,002.39** | **258,081,506.08** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 157,412,591.00 | 170,311,837.56 |
| 210101 | Үндсэн цалин | 109,890,279.50 | 120,469,969.56 |
| 210102 | Нэмэгдэл | 39,713,291.50 | 28,796,315.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 402,000.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 7,407,020.00 | 21,045,552.70 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,531,696.96 | 22,268,791.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 16,349,496.96 | 15,103,291.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,487,900.00 | 1,791,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,190,700.00 | 1,433,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 297,700.00 | 358,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,205,900.00 | 3,582,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 48,166,560.43 | 44,970,858.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,853,990.43 | 1,505,738.34 |
| 210302 | Түлш, халаалт | 45,393,470.00 | 42,287,120.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 919,100.00 | 1,178,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 4,972,344.00 | 4,736,320.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,428,050.00 | 758,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,185,694.00 | 810,650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 592,000.00 | 640,670.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,766,600.00 | 2,526,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,416,910.00 | 12,998,709.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 782,100.00 | 2,138,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,579,010.00 | 10,215,709.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,055,800.00 | 645,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 227,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 227,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 230,000.00 | 560,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 230,000.00 | 560,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 350,100.00 | 575,900.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 350,100.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 575,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,629,800.00 | 1,430,790.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,629,800.00 | 1,430,790.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **36,422,497.61** | **32,487,831.92** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 00.00 | 4,953,138.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 4,953,138.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 22,699,058.04 | 27,479,952.26 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 22,699,058.04 | 27,479,952.26 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 13,723,439.57 | 54,741.66 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 13,723,439.57 | 54,741.66 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **5,282,834.00** | **9,007,800.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **5,282,834.00** | **9,007,800.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **5,282,834.00** | **9,007,800.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 5,282,834.00 | 9,007,800.00 |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | 202,934.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 5,079,900.00 | 9,007,800.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-5,282,834.00** | **-9,007,800.00** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 206,932,400.00 | 212,384,225.00 | 317,100,600.00 | 294,624,000.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 206,932,400.00 | 212,384,225.00 | 317,100,600.00 | 294,624,000.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 206,932,400.00 | 212,384,225.00 | 317,100,600.00 | 267,089,306.08 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 125,047,000.00 | 133,887,673.00 | 179,106,400.00 | 170,311,837.56 |
| 210101 | Үндсэн цалин | 91,711,600.00 | 100,552,273.00 | 115,863,100.00 | 120,469,969.56 |
| 210102 | Нэмэгдэл | 22,330,000.00 | 21,021,993.00 | 50,606,500.00 | 28,796,315.30 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 | 500,000.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 11,005,400.00 | 12,313,407.00 | 12,136,800.00 | 21,045,552.70 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 15,630,900.00 | 16,599,856.00 | 24,183,500.00 | 22,268,791.18 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,629,000.00 | 11,772,601.00 | 17,018,000.00 | 15,103,291.18 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,000,400.00 | 1,075,855.00 | 1,791,400.00 | 1,791,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,250,500.00 | 1,000,400.00 | 1,433,100.00 | 1,433,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 250,100.00 | 250,100.00 | 358,300.00 | 358,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,500,900.00 | 2,500,900.00 | 3,582,700.00 | 3,582,700.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24,310,000.00 | 19,680,038.00 | 65,025,700.00 | 44,970,858.34 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,100,000.00 | 1,762,138.00 | 3,100,000.00 | 1,505,738.34 |
| 210302 | Түлш, халаалт | 19,500,000.00 | 16,444,000.00 | 60,215,700.00 | 42,287,120.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,710,000.00 | 1,473,900.00 | 1,710,000.00 | 1,178,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,471,200.00 | 2,826,371.00 | 7,194,800.00 | 4,736,320.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 563,200.00 | 610,745.00 | 1,464,400.00 | 758,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 899,800.00 | 899,900.00 | 1,590,200.00 | 810,650.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 500,000.00 | 332,000.00 | 700,000.00 | 640,670.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 38,900.00 | 38,900.00 | 72,300.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 469,300.00 | 944,826.00 | 3,367,900.00 | 2,526,700.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| **2105** | **Норматив зардал** | 31,607,900.00 | 31,752,162.00 | 35,798,200.00 | 12,998,709.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 44,700.00 | 44,600.00 | 2,557,400.00 | 2,138,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 31,000,000.00 | 31,707,562.00 | 31,185,000.00 | 10,215,709.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 563,200.00 | 00.00 | 2,055,800.00 | 645,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 627,500.00 | 575,300.00 | 627,500.00 | 227,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 627,500.00 | 575,300.00 | 627,500.00 | 227,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 200,000.00 | 809,426.00 | 1,084,900.00 | 560,700.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 200,000.00 | 809,426.00 | 1,084,900.00 | 560,700.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 00.00 | 300,000.00 | 650,900.00 | 575,900.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 300,000.00 | 650,900.00 | 575,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7037900.00 | 5953399.00 | 3428700.00 | 10438590.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 337,900.00 | 290,825.00 | 00.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6,700,000.00 | 5,662,574.00 | 3,428,700.00 | 10,438,590.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 181,994,900.00 | 212,350,300.00 | 317,130,600.00 | 294,624,000.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 181,994,900.00 | 212,350,300.00 | 251,477,400.00 | 249,370,800.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 181,994,900.00 | 212,350,300.00 | 251,477,400.00 | 249,370,800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 00.00 | 00.00 | 65,653,200.00 | 45,253,200.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 14.00 | 14.00 | 14.00 | 14.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 04.00 | 04.00 | 04.00 | 04.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 09.00 | 09.00 | 09.00 | 09.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал,

аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын аудитор Б.Мөнхнасан гүйцэтгэж, аудитын менежер Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж дүгнэлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино. Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалтай байна гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 299,5 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 2,9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 1,9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 729,1 | 172,0 | 557,1 |
| Бараа материал | 36,352,8 | 32,024,5 | 4,328,3 |
| Үндсэн хөрөнгө | 1,472,125,7 | 1,446,661,8 | 25,463,9 |
| **Нийт хөрөнгө** | 1,509,207,7 | 1,478,858,3 | 39,517,6 |
| Өр төлбөр | 0 | 9,168,1 | 9,168,1 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,509,207,7 | 1,478,858,3 | 39,517,6 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,509,207,7 | 1,478,858,3 | 39,517,6 |

Бараа материалын дансны үлдэгдэл 557,1 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын зардал гаргаж зарцуулсантай холбоотой байна

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 25,463,9 мянган төгрөгөөр буурсан нь тоног төхөөрөмж, тавилга хэрэгсэл акталсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 299,5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 331,5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 45,2 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 249,3 сая төгрөгийг зарцуулж, 27,4 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал гараагүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн анхан шатны баримтын бүрдүүлэлт сайн, Санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн цагалбар, болон НББ-ийн тухай хууль, Сангийн сайдын 388 дугаар тушаалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Төсвийн тухай хууль болон НББ-ийн тухай хууль бусад заавар журмыг дагаж мөрдсөн

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжиийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлаас бэлтгэж байгаа хөрөнгийн дансуудыг зөв сонгож бүртгэх, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж хөрөнгө бэлтгэхгүй байх талаар анхаарч ажиллах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,6 сая төгрөгийн алдаанд төлбөрийн акт хүргүүлж, 0,1 сая төгрөгийн алдаанд зөвлөмж өгсөн байна.

### 4.1 Залруулсан алдаагүй

### 4.2 Төлбөрийн акт тогтоосон

Түлш халаалтын хэмнэсэн зардлаас түлээ нүүрсний хөнгөлөлт 14 ажилтанд олгосонд акт тогтоосон

### 4.3 Албан шаардлага өгөгдөөгүй болно.

### 4.4 Зөвлөмж

Зардлуудыг зориулалтын дагуу зарцуулж тайлагнаж байх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1. | Дөрвөлжин сум Хүүхдийн цэцэрдлэг | 2 | 1,7 | 0 | 0 | 1 | 1,6 | 0 | 0 | 1 | 0,1 |